



Шинжээчийн тайлан

/Хөтөлбөрийн ахиц дэвшил/

Байгууллагын нэр: Монгол Улсын Эрдмийн Их сургууль

Хөтөлбөрийн нэр: Гадаад хэл, шинжлэл

/Докторын зэрэг олгох сургалтын хөтөлбөр/

Индекс: F02320202

Шинжээч: Г.Томтогтох ШУТИС, доктор, профессор

2022.05.23

Агуулга

I.Товчилсон үгийн тайлбар

II. БМИҮЗ. Дээд боловсролын магадлан итгэмжлэх комиссын тогтоол “Мэргэжлийн зөвлөлийн шийдвэрийг батламжлах тухай” 2021 оны 04 сарын 26, №03

Дээд боловсролын магадлан итгэмжлэх комиссын 2021 оны 04 сарын 26-ны №03 тоот тогтоолын хавсралт

III. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

IV. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

V.Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

ШААРДЛАГА:

Шаардлага 1. Шалгуур 3. Докторантын үнэлгээ, хөгжил 3.1. Суралцагчийн үнэлгээ, шалгалт

Шаардлага 2. Шалгуур 3. Докторантын үнэлгээ, хөгжил 3.4. Докторын хөтөлбөрийн хэрэгжилт

Шаардлага 3. Шалгуур 4. Багшлах бүрэлдэхүүн. 4.1. Багшийн нөөц.

Шаардлага 4. Шалгуур 6. Чанарын баталгаажуулалт. 6.1. Чанарын дотоод баталгаажуулалт ба хөтөлбөрийн сайжруулалт

ЗӨВЛӨМЖ:

Зөвлөмж 1. Шалгуур 1. Докторын хөтөлбөрийн зорилго, агуулга. 1.2 Хөтөлбөрийн зорилго

Зөвлөмж 2. Шалгуур 3. Докторын хөтөлбөрийн хэрэгжилт. 2.3.Судалгааны болон суралцах арга зүй. 2.5.Судалгаа, хамтын ажиллагаа

Зөвлөмж 3. Шалгуур 3. Докторантын үнэлгээ, хөгжил. 3.4. Судалгааны санхүүжилт. 3.5. Докторантыг дэмжих, зөвлөх үйлчилгээ

Зөвлөмж 4. Шалгуур 5. Нөөц ба удирдлагын мэдээллийн систем. 5.2. Сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн

ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТ

VI.Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

VII. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

VIII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

I. Товчилсон үгийн тайлбар

АШУҮИС –Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их сургууль
БМИҮЗ - Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөл
БНХАУ- Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БСШУСЯ - Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
БСШУЯ - Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
БТМ - Бодлого, төлөвлөлт, мониторинг
БТМА - Бодлого, төлөвлөлт, мониторингийн алба
БШУЯ - Боловсрол шинжлэх ухааны яам
БУ-Боловсролын удирдлага
ГХШ-Гадаад хэл шинжлэл
ГХШХ - Гадаад хэл шинжлэлийн докторын хөтөлбөр
ДМБЭ- Докторант, магистрантын бүтээлийн эмхэтгэл
ДХИС – Дотоод Хэргийн Их сургууль
МБСБ - Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага
МУЭИС - Монгол Улсын Эрдмийн Их сургууль
МУБИС-Монгол Улсын Боловсролын Их сургууль
МҮХАҮТ - Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим
МҮОНРТ - Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевиз
МУБИС - Монгол Улсын Боловсролын Их сургууль
МУИС - Монгол Улсын Их сургууль
НҮБ - Нэгдсэн Үндэстний Байгууллага
НХУС - Нийгэм хүмүүнлэгийн ухааны сургууль
ОХУ - Оросын Холбооны Улс
ӨҮТ - Өөрийн үнэлгээний тайлан
СНА - Сургалтын нэгдсэн алба
СУИС-Соёл Урлагийн Их сургууль
ТББ - Төрийн бус байгууллага
ХИС - Хүмүүнлэгийн Ухааны Их сургууль
ХСС - Хэл соёлын сургууль
ХШГХШПБ - Хэл шинжлэл, гадаад хэл, шинжлэлийн профессорын баг
ХШҮГ –Хяналт, шинжилгээ, үнэлгээний газар
ШУА - Шинжлэх Ухааны Академи
ШУТИС - Шинжлэх Ухаан Технологийн Их сургууль
ЭШБ- Эрдэм шинжилгээний бичиг

II. БМИҮЗ. Дээд боловсролын магадлан итгэмжлэх комиссын тогтоол “Мэргэжлийн зөвлөлийн шийдвэрийг батламжлах тухай” 2021 оны 04 сарын 26, №03

Дээд боловсролын магадлан итгэмжлэх комиссын 2021 оны 04 сарын 26-ны №03 тоот тогтоолын хавсралт



БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ
ДЭЭД БОЛОВСРОЛЫН
МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ КОМИССЫН
ТОГТООЛ

2021 оны 04 сарын 26 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Мэргэжлийн зөвлөлийн шийдвэрийг
батламжлах тухай


“Дээд боловсролын тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.12 дахь заалт, “Боловсролын магадлан итгэмжлэх байгууллагын дүрэм”-ийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалт, “Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн дүрэм”-ийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалт, “Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам”-ын 2 дугаар зүйлийн 2.3.6 дахь заалт, “Магадлан итгэмжлэх комиссын үйл ажиллагааны журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалт, Дээд боловсролын магадлан итгэмжлэх комиссын 2021 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол улсын Эрдмийн Их сургуулийн “Гадаад хэл, шинжлэл” F02320202 докторын хөтөлбөр нь магадлан итгэмжлэлийн шалгуур, шаардлагыг хэсэгчлэн хангасан тул 1 жилийн хугацаатай нөхцөлтэйгөөр магадлан итгэмжилсүгэй.

2. Сургалтын хөтөлбөрийн чанарын ахиц дэвшилд комиссоос өгөх зөвлөмжийг хавсралтаар баталсугай.

3. Зөвлөмж, шаардлагыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлж ажиллах ба хэрэгжилтэд өөрийн үнэлгээ хийж, ахиц дэвшлийн тайланг 2022 оны 2 дугаар улиралд багтаан Ажлын албанд ирүүлэхийг Монгол улсын Эрдмийн Их сургуулийн захирал /Ч.Зэгиймаа/-д үүрэг болгосугай.

4. Хөтөлбөрийг магадлан итгэмжилсэн тухай шийдвэрийг мэдээллийн санд бүртгэж, шинжээчийн багийн тайлан, комиссын шийдвэрийг сургуульд хүргүүлж ажиллахыг Ажлын албаны захирал /О.Янжмаа/-д даалгасугай.

КОМИССЫН ДАРГА  Д.ГЭРЭЛМАА

210000066

Дээд боловсролын магадлан
итгэмжлэх комиссын 2021 оны 04
дүгээр сарын 26-ны өдрийн 03
тогтоолын хавсралт

Сургуулийн нэр	Монгол Улсын Эрдмийн их сургууль
Хөтөлбөрийн нэр	Гадаад хэл, шинжлэл
Хөтөлбөрийн индекс	F02320202
Шаардлага:	
3.1.Суралцагчийн үнэлгээ, шалгалт	<ul style="list-style-type: none"> • Үнэлгээний нэгдсэн системийг бүрдүүлэх, гарсан үр дүнг задлан шинжлэх, дүгнэх ажлыг тогтмолжуулах, эдгээрт үндэслэн хөтөлбөрөө сайжруулах;
3.4. Судалгааны санхүүжилт	<ul style="list-style-type: none"> • Хөтөлбөрийн санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, хөтөлбөрийн дунд хугацааны бодлого, төлөвлөлтийг хийх;
Шалгуур 4. Багшлах бүрэлдэхүүн	<ul style="list-style-type: none"> • Үндсэн багшийн тоог нэмэгдүүлж, багшийн залгамж халааг бэлтгэх; • Салбар дундын судалгаа, хамтарсан хөтөлбөрийг хөгжүүлж, үр дүнг түгээн дэлгэрүүлэх;
Шалгуур 6. 1 Чанарын баталгаажуулалт	<ul style="list-style-type: none"> • PDSA циклээр чанарын удирдлагын тогтолцоо бүрдүүлэх;
Зөвлөмж:	
Шалгуур 1. Докторын хөтөлбөрийн зорилго, агуулга	<ul style="list-style-type: none"> • Орчин үеийн хэрэгцээ шаардлага, тавигдаж байгаа зорилго, зорилтыг мэдэрсэн шинэ маягийн судалгааны сургууль болж хөгжих бодлогоо үе шаттай хэрэгжүүлэх; • Судалгааны сэдэв, сургалтын кредитэд тооцогдох эрдэм шинжилгээний илтгэл, өгүүллийг тодорхой судалгааны ажил, төсөл хөтөлбөртэй холбож, оюутан оролцогч гүйцэтгэгч байхаар зохион байгуулах;
Шалгуур 2. Докторын хөтөлбөрийн хэрэгжилт	<ul style="list-style-type: none"> • Докторант бие даан суралцах орчин үеийн аргыг эзэмших, судалгааны ажилд ашиглах арга зүйд суралцах боломжийг нэмэгдүүлэх; • Багш, докторантуудыг судалгааны багт оролцох идэвхийг нэмэгдүүлэх, тоог өсгөх;
Шалгуур 3. Докторантын үнэлгээ, хөгжил	<ul style="list-style-type: none"> • Суралцагчдын судалгааг санхүүжүүлэх эх үүсвэр, дотоод, гадаадын тэтгэлэгт хамруулах боломжийг нэмэгдүүлэх; • Тухайн хөтөлбөрөөр төгсөгчдийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагад хөндлөнгийн үнэлгээ тогтмол хийж, үр дүнг тооцох;
Шалгуур 5. Нөөц баг удирдлагын мэдээллийн систем	<ul style="list-style-type: none"> • Ном, сурах бичиг, гарын авлага болон бусад хэрэглэгдэхүүний чанар, тоог цаашид тасралтгүй нэмэгдүүлэх; • Сургалтын болон судалгааны лабораториудыг байгуулах;

----- 000 -----

III. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	Монгол Улсын Эрдмийн Их сургууль Graduate University of Mongolia
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи	Гадаад, хэл шинжлэл
Индекс	F02320202
Шинжээчид	Г.Томтогтох ШУТИС, доктор, профессор
БМИУЗ-ийн мэргэжилтэн	Г.Даваажаргал, доктор

Монгол Улсын Эрдмийн Их сургуулийн “Гадаад хэл шинжлэл” F02320202 хөтөлбөрт хөндлөнгийн үнэлгээ хийх ажлын хуваарь

Огноо: 2022-05-11 10:00-16:00

Хугацаа	Үйл ажиллагаа	Хаана
2022-05-17 Мягмар гараг		
10:00-10:30	Шинжээч магадлан итгэмжлэлийн үйл явц, хуваарийг танилцуулна. Хөтөлбөрийн товч танилцуулга /тайлан бичсэнээс хойших мэдээллийг оруулах/	МУЭИС
10:30-11:00	Сургуулийн орчинтой танилцах /ӨҮТ-нд бичигдсэн материаллаг орчин/	Номын сан, компьютерын лаборатори гм
11:00-13:00	Тайлантай холбоотой нотлох баримттай танилцах, холбогдох хүмүүсээс тодруулга, лавлагаа авах	МУЭИС
13:00-14:00	Үдийн завсарлага	
14:00-15:30	Тайлантай холбоотой нотлох баримттай танилцах, холбогдох хүмүүсээс тодруулга, лавлагаа авах	МУЭИС
15:30-16:00	Шинжээч урьдчилсан дүгнэлтийг байгууллагад мэдэгдэнэ.	МУЭИС

IV. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

МУЭИС гадаад хэл, хэл шинжлэлийн онол, практикийн өндөр мэдлэгтэй, олон шинжлэх ухааны уулзварт эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх дадал, чадвар эзэмшсэн, үндэсний болон олон улсын хөдөлмөрийн зах зээл дээр хөрвөн ажиллах чадвартай, мэдлэг, чадвараараа нийгэм, олон нийтэд мэргэжлийн өндөр түвшинд үйлчлэх докторын зэрэгтэй мэргэжилтэн бэлтгэх зорилгоор гадаад хэл, шинжлэлийн докторын хөтөлбөрийг хэрэгжүүлж иржээ.

“Гадаад хэл шинжлэл” докторын хөтөлбөрийг Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, БШУСЯ-ын 2014 оны А/370 тоот тушаалаар батлагдсан “Магистр, докторын сургалт эрхлэх нийтлэг журам”-ыг үндэс болгохын зэрэгцээ МУЭИС-ийн 2016-2026 оны хөгжлийн стратегийн төлөвлөгөө, Захирлын 2016 оны 8-р дугаар сарын 11-ний өдрийн 04 тоот тушаалын 32-р хавсралтаар батлагдсан “МУЭИС-ийн магистр, докторын сургалтын журам”-ыг баримтлан хэрэгжүүлж байна.

Бүтэц, зохион байгуулалтын хувьд өөрчлөгдсөн ч тус сургууль “Гадаад хэл шинжлэл” докторын хөтөлбөрөө тасралтгүй хэрэгжүүлж, оролцогч талуудын эрэлт хэрэгцээнд нийцүүлэн хөтөлбөрийн баримт бичгийг тогтмол сайжруулсаар ирсэн.

Хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн 1999 оноос хойш сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийг нийт 5 удаа өөрчлөн, сунгуулж байсан бөгөөд сүүлийн 5 жилд 2 удаа (сургуулийн статус өөрчлөгдсөн, хөтөлбөрийн индекс өөрчлөгдсөн шалтгаанаар) шинэчлэн батлуулсан байна.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч үндсэн нэгж нь Хөтөлбөрийн дэд хороо буюу Хэл шинжлэл, гадаад хэл, шинжлэлийн профессорын баг /ХШГХШПБ/ юм. Профессорын баг нь багийн ахлагч, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэх бөгөөд жил бүр захирлын тушаалаар батлагддаг.

Докторантын суралцах хугацаанд хийх судалгааны төлөвлөлт, чанарын баталгаажуулалтыг “МУЭИС-ийн магистр, докторын сургалтын журам”-ын 2 дугаар зүйлд; хэрэгжилтийг 3 дугаар зүйл заалтад тусгасан байна. “МУЭИС-ийн магистр, доктор (Ph.D)-ын сургалтын журам”-ын 2.4.3.-т “Академик эрх чөлөөг хүндэтгэх үүднээс магистрант, докторант нь судалгааны ажлын төлөвлөгөөгөө гарган, эрдэм шинжилгээний удирдагчаар батлуулна”, 3.1.9.-д “Суралцагч удирдагчтайгаа зөвшилцөн ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулан ажиллах тохиолдолд сургалт, судалгааны ажлын төлөвлөгөөг батлах, өөрчлөлт оруулах асуудлыг профессорын багийн Их семинараар шийднэ” зэргээр тусгайлан журамлажээ.

2022 оны байдлаар ХУИС, МУЭИС-ийг төгссөн 230 гаруй докторуудаас МУИС, ШУТИС, МУБИС, ДХИС, ХААИС, АШУУИС, СУИС зэрэг дотоодын их дээд сургууль, Англи, ОХУ, БНХАУ, Казахстан, Турк зэрэг гадаадын улс орны их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагаас элссэн 60 гаруй гадаад хэлний эрдэмтэн төрөн гарсан байна.

Хөтөлбөрийг БМИҮЗ, Дээд боловсролын магадлан итгэмжлэх комиссын 2021 оны 4 сарын 26-ны 3 тоот тогтоолоор 1 жилийн нөхцөлтэйгээр магадлан итгэмжилсэн байна.

V. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

БМИҮЗ, Дээд боловсролын магадлан итгэмжлэх комиссын 2021 оны 4 сарын 26-ны 3 тоот тогтоолын хавсралтад заасан 4 шаардлага, 4 зөвлөмжийн дагуу шинжээч үнэлгээ хийж дүгнэлт гаргав.

ШААРДЛАГА

ШААРДЛАГА 1 (3.1). *Үнэлгээний нэгдсэн системийг бүрдүүлэх, гарсан үр дүнг задлан шинжлэх, дүгнэх ажлыг тогтмолжуулах эдгээрт үндэслэн хөтөлбөрөө сайжруулах.*

3.1.Суралцагчийн үнэлгээ, шалгалт

Хөтөлбөрийн явцад үнэлгээний олон төрөл хэлбэрийг ашиглан суралцагчийн суралцахуйн зорилтот үр дүн (мэдлэг, чадвар, дадал)-гийн гүйцэтгэлийг үнэлэх тогтолцоотой байна. Үнэлгээний журам, шалгуур нь оюутны сурлагын амжилтыг шударга ил тод үнэлэхэд чиглэсэн байна. Суралцагчийн мэдлэг, чадвар, дадлыг цогцоор үнэлэх шалгалтын материалын санг хичээл бүрээр боловсруулж, ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

- 2016 оны 04 тоот тушаалын 02 дугаар хавсралтаар “МУЭИС-ийн магистр, доктор (Ph.D)-ын сургалтын журам”, 2016 оны 04 тоот тушаалын 04 дүгээр хавсралтаар “Суралцагчийн мэдлэг, чадварыг үнэлэх нийтлэг журам”, 2020 оны 18 тоот тушаалын 1-р хавсралтаар “Цахим хичээл боловсруулах болон сургалт зохион байгуулах удирдамж” тус тус батлагдсан бөгөөд эдгээрт заасны дагуу суралцагчийн үнэлгээг зохион байгуулж, зохицуулж байна.
- Ахиц дэвшлийн тайлангийн хугацаанд *Үнэлгээний нэгдсэн системийг бүрдүүлэх, гарсан үр дүнг задлан шинжлэх, дүгнэх ажлыг тогтмолжуулах, эдгээрт үндэслэн хөтөлбөрөө сайжруулахад чиглэсэн* тогтолцоог анхдагч, хоёрдогч, гуравдагч түвшний үнэлгээ гэсэн бүтцээр бүрдүүлсэн байна. Анхдагч түвшний үнэлгээ–хичээл бүрийн болон нэгдсэн шалгалтын үнэлгээ; хоёрдогч түвшний үнэлгээ- суралцагч, төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгаа; гуравдагч түвшний үнэлгээ-ажил олгогч, магадлан итгэмжлэл, бусад хөндлөнгийн үнэлгээ.
- Хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд суралцахуйн зорилго, зорилт (PEOs), хөтөлбөрийн суралцахуйн үр дүн (PLOs), хичээлийн суралцахуйн үр дүн (CLOs)-г үнэлгээний арга хэлбэртэй холбон боловсруулсан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Танин мэдэхүйн (Cognitive domain), хувь хүний хандлагын (Affective domain), бүтээлч байдал (Psychomotor domain)-ын түвшинд харгалзуулан үнэлгээний арга, хэлбэрийг шинэчлэх ажлыг эхлүүлсэн байна.

ШААРДЛАГА 2 (3.4). Хөтөлбөрийн санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, хөтөлбөрийн дунд хугацааны бодлого төлөвлөлт хийх

3.4. Судалгааны санхүүжилт

Докторын судалгааг санхүүжүүлэх, санхүүжилтийг хянах ил тод бодлого, журамтай байна. Энэ нь сургуулийн судалгааны бодлого, зорилготой нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

1. Сургалтын төлбөрөөс орох орлого нэмэгдсэн. 2019-2020 оны хичээлийн жилд 10%, 2020-2021 онд 18% нэмэгдсэн. Гадаад оюутны элсэлт 3 дахин нэмэгдсэн.
2. Сургуулийн дэргэдэх төвүүдийн үйл ажиллагааг сайжруулж төлбөрт үйлчилгээнүүдийг нэмэгдүүлсэн. Сүүлийн 1 жилд “Докторантад үйлчлэх төв” байгуулсан. Үйлчилгээний орлого 9350 мянган төгрөг болсон.
3. Сургуулиас эрхлэн гаргадаг эрдэм шинжилгээний бичиг, бүтээлийн эмхэтгэлд бүтээлээ хэвлүүлэх, ном, эмхэтгэлийн борлуулалтаас олох орлого нэмэгдүүлэх арга хэмжээ авсны дүнд ирүүлсэн бүтээл, борлуулсан бүтээлийн тоо нэмэгдэж санхүүжилтэд оруулах хувь хэмжээ 2019-2020 онд 20%, 2020-2021 онд 21% нэмэгдсэн, орлого 5194 мянган төгрөг. Бусад үйлчилгээнээс 9240 мянган төгрөгийн орлого олсон баримт байна.
4. 2019 оноос БНХАУ-ын “Нэг бүс-нэг зам” ОУ-ын хөгжлийн судалгааны академитэй хамтын ажиллагааны гэрээ байгуулж ажилласнаар тус байгууллага 5 оюутны сургалтын зардлыг бүрэн даасан нь хөтөлбөрөөр суралцагчдыг идэвхжүүлэх, тоог нэмэгдүүлэхэд түлхэц үзүүлж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Монгол Улсад докторын сургалтын санхүүжилт маш хүндрэлтэй. Судалгааны их сургуулийн эрх зүйн орчин, санхүүжилтийн тогтолцоо бүрдээгүй.
- Докторын сургалтын зардал өндөр, суралцагчдын тоо цөөн /тухайн хөтөлбөрт суралцагчдын нийт тоо жилд дунджаар 33/
 - Хэлний чиглэлээр, тухайлбал гадаад хэл шинжлэлийн чиглэлээр 1999 оноос эхэлсэн сургалтыг тасралтгүй, хариуцлагатай авч явах, хөгжүүлэхэд чиглэсэн бодлого барьж ажиллаж байна.

Зөвлөмж: Байгууллагын захиалгаар доктор бэлтгэх, судалгаа хийх чиглэлээр санхүүжилтийн эх үүсвэр бүрдүүлэх боломж судлах.

ШААРДЛАГА 3 (4.1). – Үндсэн багшийн тоог нэмэгдүүлэх, багшийн залгамж халааг бэлтгэх, салбар дундын судалгаа хамтарсан хөтөлбөрийг хөгжүүлж үр дүнг түгээн дэлгэрүүлэх.

4.1. Багшийн нөөц

Тухайн хөтөлбөрийн мэргэжлийн чиглэл, боловсролын зэргийн түвшинд тохирсон боловсролын зэрэг, эрдмийн цолтой, багшлах өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багш, судлаачийн нөөцтэй байна. Багш, оюутны тооны харьцааг зохистой тогтоож, мөрддөг байна.

Илрэл нотолгоо:

- Багшлах бүрэлдэхүүний хувьд Монгол Улсын бодлогын бичиг баримтад боловсролын байгууллагуудын академик эрх чөлөөг хангах тухай заалт, ахисан түвшний сургалтын байгууллагын онцлогтой нийцүүлэн багшлах бүрэлдэхүүнийг тогтмол /статик/ бус уян хатан /динамик/ бүтэцтэй байхаар төлөвлөж хэл шинжлэлийн чиглэлийн 160 эрдэмтэн

судлаачдын бүртгэл бүхий сан байгуулж хичээл заах, докторын судалгааны ажил удирдах, онол, хэрэглээний сургалт, семинар зэргийг явуулахад гэрээ байгуулж ажилладаг.

- Докторын сургалтыг Хэл шинжлэл, гадаад хэл шинжлэлийн профессорын баг эрхлэн явуулдаг. Багийн бүрэлдэхүүнийг жил бүр захирлын тушаалаар баталж үйл ажиллагаа явуулдаг. 2021-2022 оны хичээлийн жилд 12 эрдэмтэн багш ажиллаж байгаа, 100% доктор Ph.D, Sc.D зэрэгтэй.
- 2021 онд БНХАУ-ын Xi An University, Bohai University сургуультай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулан салбар дундын судалгаа, докторын хөтөлбөр хэрэгжүүлэхэд хамтран ажиллах эхлэл тавьсан.
- Сүүлийн 2 жил БНХАУ, Казахстаны их дээд сургуулийн эрдэмтэн багш нартай хамтран ажиллаж багшийн нөөцийг бэхжүүлж байна. “Нэг бүс, нэг зам” олон улсын хөгжлийн академитэй хамтран “Зуун эрдэмтэн, зуун докторант” хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлж хамтарсан судалгаа, багш, оюутан солилцоо, хурал, семинар зохион байгуулж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багшлах бүрэлдэхүүнийг динамик бүтэц судалгааны сургууль, ахисан түвшний сургалтад тохиромжтой болохыг харуулсан туршлага.

ШААРДЛАГА 4 (6.1). PDSA циклээр чанарын удирдлагын тогтолцоог бүрэн бүрдүүлж ажиллах

6.1. Чанарын дотоод баталгаажуулалт ба хөтөлбөрийн сайжруулалт

Хөтөлбөрийн хэрэгжилтийг бүхэлд нь болон үе шат бүрийг, түүнчлэн бүрэлдэхүүн хэсэг (хичээлийн хөтөлбөрүүд, суралцахуйн орчин, багшлахуй ба суралцахуйн үнэлгээ, элсэлт ба төгсөлт, төгсөлтийн ажил эрхлэлт гэх мэт) тус бүрийг байнга хянан үнэлж, тухай бүр сайжруулах чанарын дотоод баталгаажуулалтын тогтолцоотой байна. Чанарын дотоод баталгаажуулалтын бүтэц, үйл явцад бүх талуудын оролцдог байна.

Илрэл нотолгоо:

- МУЭИС-ийн бодлого төлөвлөлт, мониторингийн нэгж нь дотоод чанарын баталгаажуулалтыг гүйцэтгэх зорилгоор 2014 оноос байгуулагдаж, ЧДБ-ын гарын авлага болон сургалтын чанарыг сайжруулах бодлогыг тодорхойлж, холбогдох бичиг баримтыг боловсруулан хэрэгжүүлж байна.
- Чанарын баталгаажуулалтын үйл ажиллагааг Олон улсын чанарын удирдлагын ISO 9001:2015 стандартын дагуу PDSA циклээр хэрэгжүүлж ирсэн. Үүнийг нотлох баримт “Чанарын дотоод баталгаажуулалт, Чанарын дотоод баталгаажуулалтын гарын авлага 2021” гарын авлагууд, МУЭИС-ийн сургалтын хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын журам, МУЭИС-д үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сүүлийн жилүүдэд сургуулийн хяналт шинжилгээний тогтолцоо бүрдэж байгаагийн нэг илрэл нь багш ажилтны ажлын өөрийн үнэлгээний хагас, бүтэн жилийн тайлан, сургуулийн хагас, бүтэн жилийн тайланг тогтмол хэлэлцэж үр дүнг тооцож ажилласан байна.
- Анхдагч үнэлгээ нь хөтөлбөрийн хичээл бүрийн болон нэгдсэн шалгалтын дүнгээр, хөтөлбөрийн хоёрдогч үнэлгээг суралцагчдын сэтгэл ханамжийн судалгаа, гуравдагч үнэлгээг хөндлөнгийн үнэлгээ ажил олгогчдоос авсан судалгаа, магадлан итгэмжлэл.

Зөвлөмж:

- Чанарын баталгаажуулалтын талаарх дүрэм журам, шаардлагын хэрэгжилтийг цаашид тасралтгүй сайжруулахад анхаарах;

ЗӨВЛӨМЖ

ЗӨВЛӨМЖ 1 (1.2).

- Орчин үеийн хэрэгцээ шаардлага, тавигдаж байгаа зорилго, зорилтыг мэдэрсэн шинэ маягийн судалгааны сургууль болж хөгжих бодлогоо үе шаттай хөгжүүлэх
- Судалгааны сэдэв, сургалтын кредитэд тооцогдох эрдэм шинжилгээний илтгэл, өгүүллийг тодорхой судалгааны ажил, төсөл хөтөлбөртэй холбож оюутан оролцогч гүйцэтгэж байхаар зохион байгуулах.

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн төгсгөлд докторантын эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, дадал буюу суралцахуйн зорилтот үр дүнгээр хөтөлбөрийн зорилгыг тодорхойлсон байна. Хөтөлбөрийн зорилго нь тухайн мэргэжлийн чиглэл, боловсролын түвшингийн үндэсний болон олон улсын нийтлэг чадамжийн хүрээнд дүйцэхүйц байхын зэрэгцээ сургуулийн судалгааны бодлого, зорилгод нийцсэн (өөрийн онцлог, давуу байдлыг тусгасан) байна. Суралцахуйн зорилтот үр дүнг тодорхойлоход оролцогч талуудыг татан оролцуулж, тэдний хэрэгцээ, шаардлагыг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

1. 2016 оноос бие даасан судалгааны анхны их сургууль болсноор байгууллагын гадаад, дотоод орчны үнэлгээг макро орчны PESTLE+G шинжилгээ, Successful Strategy, SWOT шинжилгээ, SPACE матрицын шинжилгээ, Женерал Электрикийн матриц, Porter's five forces, АНП шинжилгээнүүд зэрэг математик арга, загварчлалыг ашиглан хийж, шинжлэх ухаан, дээд боловсролын ирээдүйн хөгжлийн хэтийн төлөв, чиг хандлага, өнөөгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны онцлог, давуу талаа харгалзан тус сургуулийг хөгжүүлэх Стратеги төлөвлөгөөг боловсруулж, алсын хараа, эрхэм зорилгоо "Орчин үеийн судалгаа, эрдмийн зэрэг олгох боловсролоор нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулна" /Ахиц дэвшлийн тайлан, х.31-32/ хэмээн тодорхойлсон.
2. 2020 онд 2016-2019, 2020-2023, 2021-2024 он гэсн гурван үе шаттай "МУЭИС-ийн бизнес төлөвлөгөө" баталсан.

3. Хэл шинжлэлийн докторын хөтөлбөрийн зорилгыг өөрчлөн шинэчлэхдээ МУЭИС-ийн алсын хараа, эрхэм зорилго, стратеги төлөвлөгөөнд дэвшүүлсэн зорилго, зорилтууд, хөтөлбөрт оролцогч талуудын эрэлт хэрэгцээ, суралцахуйн зорилтот үр дүнд нийцүүлэн тодорхойлж иржээ. Хөтөлбөрийн зорилгыг тодорхойлохдоо орчин үеийн судалгаа, шинжилгээний ажлыг эрчимтэй хөгжүүлж, суралцагчдын академик эрх чөлөөг хангах эрэлт, хэрэгцээ, дэлхийн жишигт нийцсэн орчин үеийн судалгааны ажил явуулах боловсролын салбарын шинэ санаа санаачилга, судалгаа, шинжилгээний ажлыг өөрийн орны нөхцөл байдалтай уялдуулах төрийн бодлого, нийгмийн захиалга, инновацийн чиг хандлага, олон улс, бүс нутгийн хэмжээнд ажиллаж чадах, хөрвөх чадвартай эрдэмтэд, залуу судлаачдыг бэлтгэх шаардлага, дээд боловсрол, шинжлэх ухааны салбарт хэлшинжлэлийг чанарын өндөр түвшинд хөгжүүлэх шаардлага, эрдмийн зэрэг олгох ахисан түвшний сургалтыг дагнан явуулдаг судалгааны анхны их сургуулийн эрхэм зорилго, нийгэм – хүмүүнлэгийн орчин үеийн судалгаа, төгсөлтийн дараах сургалтын олон жилийн туршлага зэрэг өөрийн сургуулийн давуу тал зэрэг дотоод, гадаад хүчин зүйлсийг харгалзан үзсэн байна.
4. ГХШД-ын хөтөлбөрөөр төгсөгч нь 2 багц мэдлэг (шинжлэх ухааны онолын мэдлэг шинжлэх ухааны практик мэдлэг), 4 багц чадвар (критикал сэтгэхүй, системт сэтгэхүй, коммуникац, кооператив сэтгэхүй, креатив сэтгэхүй) эзэмшиж, 1 багц (зөв) хандлага төлөвшсөн байхаар зохион байгуулсан сургалтад бүтээл хэвлүүлэх, илтгэл тавих, хурал, семинарт оролцох, зохион байгуулах хичээл заах, peer review төсөлд оролцох зэргээс сонгон кредит бүрдүүлж судалгааны ажилтай холбон боломж олгосон. /Захирлын тушаал, 2016-№45/
5. Сонгон мэргэшүүлэх хөтөлбөрүүдийг сургалт судалгааны болон чиглэлийн ТББ-тай хамтарсан кооператив болон судалгаанд сурилсан сургалтад шилжүүлэх эхлэл тавигдсан.

Шалгуурыг хангасан байдал:Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

Танихуйн болон сэтгэц, нейро, нийгэм, компьютер, интернет, соёлын хэл шинжлэл зэрэг орчин үеийн хэл шинжлэлийн чиглэл, дэг, урсгалын онолын мэдлэг олгох, судалгаа явуулахад хөтөлбөрийн агуулга ерөнхийдөө чиглэгдэж байгаа нь тухайн хөтөлбөрийн онцлог гэж үзэхээр байна.

ЗӨВЛӨМЖ 2.

- *Суралцагч бие даан суралцах орчин үеийн аргыг эзэмших, судалгааны ажилд ашиглах арга зүйд суралцах боломжийг нэмэгдүүлэх*
- *Багш, докторантуудыг судалгааны багт хамруулах боломжийг нэмэгдүүлэх*

2.3.Судалгааны болон суралцах арга зүй

Сургалтын арга зүй нь суралцагч төвтэй, хөтөлбөрийн зорилгод нийцсэн, оюутанд хөтөлбөрийн үр дүнд хүрэх боломжийг олгосон байна.

2.5.Судалгаа, хамтын ажиллагаа

Хөтөлбөрийн түвшинд үндэсний болон олон улсын, төрийн болон хувийн байгууллага, дээд боловсролын сургалтын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх гэрээтэй, дотоод болон гаднын судалгааны нэгж болон байгууллагуудтай холбоо тогтоож, түншилдэг байна. Багш, докторантууд судалгааны багт оролцдог байна.

Илрэл нотолгоо:

- МУЭИС докторын сургалтын тогтолцоогоо “агуулгад төвлөрсөн” хандлагаас “суралцахуйн зорилт”, “үр дүнд суурилсан” хандлагад шилжүүлсэн бөгөөд ажил олгогч, төгсөгчийн урт хугацааны хэрэгцээ шаардлагад нийцсэн мэдлэг, чадвар, хандлагыг эзэмшүүлж байна. Энэ хүрээнд сургалтын арга зүйг багшлахуйн бэлэн мэдлэг дамжуулалтад төвлөрдөг хандлагаас докторантын суралцахуйн бүтээлч үр дүнд чиглүүлэх болсон бөгөөд суралцахуйн зорилтод суурилан хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж /Ахиц дэвшлийн тайлан, х.34-35/ байна.
- “Онлайн хичээл бичлэггийн лаборатори” төслийн хүрээнд Гранд Ай Ти ХХК МУЭИС-ийн брэнд цахим сургалт судалгааны систем <https://gradedu855e.web.app> хөгжүүлсэн 2021-2022 онд.
- Судалгаанд ашиглах 6 программ хангамж, системийг оюутны хүртээл болгосон /Ахиц дэвшлийн тайлан х.37/
- Докторантын суралцахуй ба судалгааны ажлыг дэмжих, судалгааны багт ажиллах боломжийг хангах эрх зүйн 3 баримт бичиг, тушаал шийдвэр гаргасан /2020 оноос хойш, Ахиц дэвшлийн тайлан, х.38/
- Багш, докторантуудыг судалгааны багт хамруулах боломжийг нэмэгдүүлснээр сүүлийн 5 жилд 7 докторант төсөл хөтөлбөрт хамрагдсан.

Онцлог зүйл/Туршлага:

- Гадаад хэл шинжлэл докторын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлдэг, судалгааны арга зүйд суралцдаг нэг гол хэлбэр нь Их семинар болж байна. Докторантын ажлыг хэлэлцэх Их семинар нь докторантын судалгааны ажлын явцад зөвлөн туслах, удирдан чиглүүлэх зорилготой бөгөөд эдгээр их семинарт оролцох явцад суралцагчид мөн сургалтын журмын дагуу кредит цуглуулах боломжтой.
- Сургалт, судалгаа, удирдагч багшийн үйл ажиллагаатай холбоотой докторантын сэтгэл ханамжийн судалгаа авч байгаа нь цаашдын ажил үйлчилгээг сайжруулахад түлхэц болж байна.

Анхаарах асуудал:

- Сургуулийн ЭШБ, МДБЭ-ээс гадна гадаад, дотоодын бусад нэр хүндтэй хэвлэлд докторантууд бүтээлээ хэвлүүлэхэд анхаарах.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

ЗӨВЛӨМЖ 3.

- *Суралцагчдын судалгааг санхүүжүүлэх эх үүсвэр, дотоод гадаад тэтгэлэгт хамруулах боломжийг нэмэгдүүлэх*
- *Тухайн хөтөлбөрөөр төгсөгчдийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагад үнэлгээ тогтмол хийж, үр дүнг тооцох*

3.4. Судалгааны санхүүжилт

Докторын судалгааг санхүүжүүлэх, санхүүжилтийг хянах ил тод бодлого, журамтай байна. Энэ нь сургуулийн судалгааны бодлого, зорилготой нийцсэн байна.

3.5. Докторантыг дэмжих, зөвлөх үйлчилгээ

Шинжлэх ухааны арга хэмжээ, бага хурал, мэргэжлийн хэлэлцүүлэг зэрэг шинжлэх ухааны болон мэргэжлийн нэмэлт арга хэмжээ, үйл ажиллагаанд докторантыг оролцуулдаг байна. Эдгээр арга хэмжээ, үйл ажиллагаанд докторантыг оролцуулах, баталгаажуулах, үнэлүүлэх тогтолцоотой байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын төлбөрөөс орох орлого нэмэгдсэн. 2019-2020 оны хичээлийн жилд 10%, 2020-2021 онд 18% нэмэгдсэн. Гадаад оюутны элсэлт 3 дахин нэмэгдсэн.
- Сургуулийн дэргэдэх төвүүдийн үйл ажиллагааг сайжруулж төлбөрт үйлчилгээнүүдийг нэмэгдүүлсэн. Сүүлийн 1 жилд “Докторантад үйлчлэх төв” байгуулсан. Үйлчилгээний орлого 9350 мянган төгрөг болсон.
- Сургуулиас эрхлэн гаргадаг эрдэм шинжилгээний бичиг, бүтээлийн эмхэтгэлд бүтээлээ хэвлүүлэх, ном, эмхэтгэлийн борлуулалтаас олох орлого нэмэгдүүлэх арга хэмжээ авсны дүнд ирүүлсэн бүтээл, борлуулсан бүтээлийн тоо нэмэгдэж санхүүжилтэд оруулах хувь хэмжээ 2019-2020 онд 20%, 2020-2021 онд 21% нэмэгдсэн, орлого 5194 мянган төгрөг. Бусад үйлчилгээнээс 9240 мянган төгрөгийн орлого олсон баримт байна.
- 2019 оноос БНХАУ-ын “Нэг бүс-нэг зам” ОУ-ын хөгжлийн судлагааны академитэй хамтын ажиллагааны гэрээ байгуулж ажилласнаар тус байгууллага 5 оюутны сургалтын зардлыг бүрэн даасан нь хөтөлбөрөөр суралцагчдыг идэвхжүүлэх, тоог нэмэгдүүлэхэд түлхэц үзүүлж байна. Их сургуулийн хэмжээнд эрдэм шинжилгээний ажлын зардал сүүлийн 4 жилд өссөн үзүүлэлтэй байна.
- Суралцагчдад суралцах хугацааны /тухайн жилийн шаардлагатай мэдээллийг агуулсан Докторантын ном, сургалтын хуанлитай, мөн шинэ элсэгчдийн хүлээн авах, ганцаарчилсан зөвлөгөө өгөх зэрэг үйл ажиллагаа тогтмолжсон.
- Суралцагчдад үйлчилгээ үзүүлэхэд Сургалтын алба, профессорын баг голлох үүрэгтэйгээс гадна 2021 оноос “Докторантад үйлчлэх төв” байгуулагдсан.
- Их семинар, эрдэмтдийн цуврал лекц, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах, эрдэм шинжилгээний бичиг, бүтээлийн эмхэтгэлд хэвлүүлэх зэргээр докторантын судалгааг дэмжих үйл ажиллагаа идэвхтэй зохион байгуулагдаг.
- Төгсөгчдийн мэдлэг, чадварын үнэлгээг хөндөнгийн үнэлгээ хэлбэрээр, ажил олгогч нараас жилд нэг удаа, төгсөгчдөөс жилд хоёр удаа авч байхаар 2021-2022 оны хичээлийн жилээс журамласан байна /Өөрийн үнэлгээний тайлан, х.41-42/.

Тайлбар: Санхүүжилт Шаардлага 2 буюу 3.4-тэй тохирч байгаа учир ижил.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Анхаарах асуудал:

- Докторын судалгааг, ялангуяа ГХШД-ын хөтөлбөрөөр суралцагчдын судалгааг санхүүжүүлсэн болон үр дүнг тооцсон байдлыг жил бүр нарийвчлан гаргахад анхаарах

ЗӨВЛӨМЖ 4.

- Ном сурах бичиг, гарын авлага бусад хэрэглэгдэхүүний чанар, тоог цаашид тасралтгүй нэмэгдүүлэх
- Сургалтын болон судалгааны лабораториудыг байгуулах.

5.2. Сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн

Хичээл тус бүрээр үндсэн сурах бичиг, сургалт, судалгааны хэрэглэгдэхүүн ашиглах орчин бүрдүүлсэн ба судалгааны ажилд шаардлагатай мэдээлэл, үр дүнгүүдийг хэвлэмэл болон цахим хэлбэрээр ашиглах боломж бүрдүүлсэн байна.

Илрэл нотолгоо:

- БМИҮЗ, Дээд боловсролын магадлан итгэмжлэх комиссын зөвлөмжийн дагуу хэл шинжлэлийн чухал, мөн сүүлийн үеийн нэр бүхий 15 бүтээлийг худалдан авч номын сангаа баяжуулсан, энэ хичээлийн жилд 15 бүтээлийг сонгоод худалдан авалтад бэлтгэсэн байна.
- Сургалт судалгааны түшиц лабораториуд: Онлайн хичээлийн бичлэгийн студи, “Эрдэм тауэр” орчуулгын товчоо, Б.Н.Ельциний нэрэмжит цахим номын сан, мэдээллийн сан, 2021 онд шинээр байгуулсан “Докторантад үйлчлэх төв”-үүд тус тус ажиллаж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

• Б.Н.Ельциний нэрэмжит Цахим номын санг 2009 онд нээсэн бөгөөд 20 хүний суудалтай, Интернетэд холбогдсон танхимд байрладаг. Судалгааны шинжилгээний бүтээлүүдийг гадаад хэлээр цахимаар унших боломжтой.

Зөвлөмж:

- Б.Н.Ельциний нэрэмжит Цахим номын сангийн үйл ажиллагааг өргөтгөн, бусад их дээд сургуулийн оюутан судлаачдад нээлттэй болгоход анхаарах

ДҮГНЭЛТ

БМИҮЗ-өөс томилсон шинжээч “Докторын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур, шаардлага”, БМИҮЗ. Дээд боловсролын магадлан итгэмжлэх комиссын тогтоол, “Мэргэжлийн зөвлөлийн шийдвэрийг батламжлах тухай” 2021 оны 04 сарын 26, №03, Дээд боловсролын магадлан итгэмжлэх комиссын 2021 оны 04 сарын 26-ны №03 тоот тогтоолын хавсралтад заасан 4 шаардлага, 4 зөвлөмжийн дагуу МУЭИС-ийн “Гадаад, хэл шинжлэл” докторын хөтөлбөрт магадлан итгэмжлэлийн үнэлгээ гаргаж байна.

Шалгуур	Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаагүй (0)	Үндэслэл, шалтгаан /хэсэгчлэн хангасан болон хангаагүй шалгуурт заавал бичнэ/
1	Шаардлага 1	2		
2	Шаардлага 2	2		

3	Шаардлага 3	2			
4	Шаардлага 4	2			
5	Зөвлөмж 1	2			
6	Зөвлөмж 2	2			
7	Зөвлөмж 3	2			
8	Зөвлөмж 4	2			
Дүгнэлт		Бүрэн хангасан			

МУЭИС-ийн Ахиц дэвшлийн тайлан, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн БМИҮЗ. Дээд боловсролын магадлан итгэмжлэх комиссын тогтоол, “Мэргэжлийн зөвлөлийн шийдвэрийг батламжлах тухай” 2021 оны 04 сарын 26, №03, Дээд боловсролын магадлан итгэмжлэх комиссын 2021 оны 04 сарын 26-ны №03 тоот тогтоолын хавсралтад заасан 4 шаардлага, 4 зөвлөмжийн дагуу МУЭИС-ийн “Гадаад, хэл шинжлэл” докторын хөтөлбөрт хийсэн магадлан итгэмжлэлийн үнэлгээ шаардлагад нийцэж байгаа тул шаардлага, зөвлөмжийг **“Бүрэн хангасан”** гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг **Урлаг, хүмүүнлэгийн** чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ

Сургуулийн нэр	Монгол Улсын Эрдмийн Их Сургууль
Хөтөлбөрийн нэр	Гадаад хэл шинжлэл
Хөтөлбөрийн индекс	F02320202
ЗӨВЛӨМЖ	
Шалгуур 3.	<ul style="list-style-type: none"> Байгууллагын захиалгаар доктор бэлтгэх, судалгаа хийх чиглэлээр санхүүжилтийн эх үүсвэр бүрдүүлэх боломж судлах;
Шалгуур 5.	<ul style="list-style-type: none"> Б.Н.Ельциний нэрэмжит Цахим номын сангийн үйл ажиллагааг өргөтгөн, бусад их дээд сургуулийн оюутан судлаачдад нээлттэй болгоход анхаарах;
Шалгуур 6.	<ul style="list-style-type: none"> Чанарын баталгаажуулалтын талаарх дүрэм журам, шаардлагын хэрэгжилтийг цаашид тасралтгүй сайжруулахад анхаарах;

Шинжээч:

Г.Томтогтох

Сургуулиас ирсэн албан бичиг



БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН
ИТГЭМЖЛЭХ ҮНДЭСНИЙ
ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБАНД

МОНГОЛ УЛСЫН ЭРДМИЙН ИХ СУРГУУЛЬ

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар
Хороо, Бага тойруу, Утас/Факс: (976) 7600-2010
Цахим шуудан: info@gradedu.mn, www.gradedu.mn

2022.08.24 № 1143
танай _____ -ны № _____ -т

Мэдэгдэл хүргүүлэх тухай

Тус сургуулийн “Гадаад хэл, шинжлэл” -ийн доктор (F02320202) - ын хөтөлбөрийн ахиц дэвшилд хөндлөнгийн үнэлгээ хийсэн БМИҮЗ-ийн шинжээчийн тайланг 2022 оны 08 дугаар сарын 22-ны өдөр хүлээн авч танилцлаа. Тайланд Дээд боловсролын магадлан итгэмжлэх комиссоос өгсөн 4 шаардлага, 4 зөвлөмж тус бүрийг “Бүрэн хангасан” гэсэн дүгнэлт гарсан байна.

Шинжээчийн тайланд дурдсан зөвлөмжийг хөтөлбөр магадлан итгэмжлэгдсэнээр хэрэгжүүлэх боломжтой гэж үзэж байна.

Шинжээчийн үнэлгээний тайлантай санал нэгтэй байгаагаа мэдэгдье.

Хүндэтгэсэн,

ЗАХИРАЛ



Ч. ЗЭГИЙМАА

ҮII. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан (огноо)
[Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх

Магадлан итгэмжлэл
олгох хугацаа

--	--

Зөвлөмж /Recommendations/

ҮIII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан (огноо)
 [Магадлан итгэмжлэх комиссын хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж /Recommendations/